

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Их-Уул дулаан” ХХК -ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/03/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн чанарын хяналт, ахлах аудитор: Н.Бадамханд
Утас: 99042699 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин.....	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	7
3.1 “Их-Уул дулаан” ХХК ба түүний үйл ажиллагаа.....	7
3.2 “Их-Уул дулаан” ХХК-ийн гадаад, дотоод орчин.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	8
3.5 Зорилтот түвшин, төлөвлөгөө, гүйцэтгэл.....	9
4. Аудитын тайлан.....	10
4.1 Ерөнхий зүйл.....	10
4.2 Материаллаг байдал.....	10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
4.4.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
4.5.1 Завсрын аудитын талаар.....	11
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	11
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. Аудитын илрүүлэлт.....	12
5.1 Төлбөрийн акт.....	12
5.2 Албан шаардлага.....	12
5.3 Зөвлөмж.....	12
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	13

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлчилгээний газар



“ИХ-УУЛ ДУЛААН” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ П.ЭРДЭНЭБИЛЭГ ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.06 № 01/2023
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Их-Уул Дулаан ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Их-Уул Дулаан ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор компанийн дүрмийг шинэчлэн баталжээ. Уг дүрмийн өөрчлөлтөөр компанийн өмчлөгч нь Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болсон байна.

Аудитын гол асуудлууд

“Их-Уул дулаан” ХХК-ын ТУЗ нь 2022 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн 9 тоот тогтоолоор Хөвсгөл аймгийн ИТХ-аас баталсан зорилтот түвшинд заасан зардлын дүнг 47.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Цаашид зорилтот түвшний зардлын хязгаарыг нэмэгдүүлэхдээ хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Их-Уул дулаан” ХХК нь 2022 оны зорилтот түвшний биелэлт 108.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу

илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 12 сарын 15 өдөр

№ 54/АБЭГД/139/Х04-2023/03
111А-СТА-011А

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Их-Уул суман дахь “Их-Уул дулаан” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- “Их-Уул дулаан” ХХК нь тайлант онд урсгал зардлаас 39,900,000 (гучин есөн сая есөн зуун мянга) төгрөгөөр албан хэрэгцээний зориулалттай барилга барьсан байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгаанаар ашиглах боломжгүй болохыг тогтоосон тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр гарснаас бусад тохиолдолд захиргааны зориулалтаар барилга шинээр барихыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд “нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1 “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”. Үүнд: 4.2.1.6. “төсвийг зориулалт бусаар зарцуулсан”, 4.2.1.11 “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоож, батлагдсан төсвийг хууль тогтоомжид нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг “Их-Уул дулаан” ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Эрдэнэбилэг, нягтлан бодогч Ч.Оюунбилэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР:

Б.ДАВААНЯМ

172000001

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022-01-01	2022-12-31
1	ХӨРӨНГӨ	0.00	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	-
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	44,546,618.88	1,648,894.15
1.1.2	Дансны авлага	30,462,003.90	31,381,044.72
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	6,244,016.16	3,001,672.23
1.1.6	Бараа материал	13,171,056.40	55,131,304.43
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	94,423,695.34	91,162,915.53
1.2.1	Үндсэн хөрөнгө	442,535,829.85	411,637,510.28
1.2.2	Биет бус хөрөнгө	27,450,400.00	27,450,400.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	24,378,082.94
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	469,986,229.85	463,465,993.22
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	564,409,925.19	554,628,908.75
2.1.1.1	Дансны өглөг	390,000.02	1,122,159.78
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	84,290.26	1,316,265.63
2.1.1.4	НДШ - ийн өглөг	(0.00)	(0.00)
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	474,290.28	2,438,425.41
2.2	Өр төлбөрийн нийт дүн	474,290.28	2,438,425.41
2.3.1	Өмч: - төрийн	452,314,117.00	452,314,117.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	81,142,118.33	81,142,118.33
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	120,890,381.54	120,890,381.54
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(90,410,981.72)	(102,156,133.53)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	563,935,635.15	552,190,483.34
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	564,409,925.42	554,628,908.75

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	418,897,359.24	476,493,238.55
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	403,241,983.95	443,758,984.37
3	Нийт ашиг (алдагдал)	15,655,375.29	32,734,254.18
5	Хүүний орлого	179,169.72	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	48,792,768.21	68,600,788.92
11	Санхүүгийн зардал	0.00	120,300.00
12	Бусад зардал	0.00	136,400.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(32,958,223.20)	(36,123,234.75)
19	Орлогын албан татварын зардал	0.00	(24,378,082.94)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(32,958,223.20)	(11,745,151.81)
22	Тайлант үеийн ашиг	(32,958,223.20)	(11,745,151.81)
24	Орлогын нийт дүн	(32,958,223.20)	(11,745,151.81)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2021 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	452,314,117.00	8,235,402.00	0.00	0.00	460,549,519.00
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	72,906,716.33	120,890,381.54	(90,410,981.72)	103,386,116.15
2022 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	452,314,117.00	81,142,118.33	120,890,381.54	(90,410,981.72)	563,935,635.15
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(11,745,151.81)	(11,745,151.81)
2022 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	452,314,117.00	81,142,118.33	120,890,381.54	(102,156,133.53)	552,190,483.34

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	495,233,099.44	522,662,149.97
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	494,964,507.44	522,662,149.97
	Бусад мөнгөн орлого	268,592.00	0.00
1.2	Мөнгөн зарлага (-)	425,475,470.04	517,559,874.70
	Ажиллагчдад төлсөн	136,452,384.00	160,925,419.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	43,927,915.46	46,770,349.66
	Бараа материал худалдан авахад төлсөн	50,964,823.37	145,334,838.00
	Ашиглалтын зардалд төлсөн	9,934,098.83	37,301,703.90
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	129,587,419.00	86,072,537.00
	Хүүний төлбөрт төлсөн	6,036,292.86	0.00
	Татварын байгууллагад төлсөн	44,991,384.52	35,157,076.14
	Даатгалын төлбөрт төлсөн	99,450.00	348,300.00
	Бусад мөнгөн зарлага	3,481,702.00	5,649,651.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	69,757,629.40	5,102,275.27
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	42,796,363.63	48,000,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	42,796,363.63	48,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(42,796,363.63)	(48,000,000.00)
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	40,000,000.00	0.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	40,000,000.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(40,000,000.00)	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(13,038,734.23)	(42,897,724.73)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	57,585,353.11	44,546,618.88
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	44,546,618.88	1,648,894.15

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Зардлын төрөл		2022 оны төлөвлөгөө	2022 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Халаалтын орлого	522,016,228.00	444,354,849.45	77,661,378.55	85.12
2	Цэвэр бохир усны орлого	13,071,276.00	19,535,798.18	-6,464,522.18	149.46
3	Бусад орлого		12,602,590	-12,602,590.00	
Нийт орлогын дүн		535,087,504.00	476,493,237.63	58,594,266.37	89.05
1	Цалин	160,326,979.00	185,773,188.00	-25,446,209.00	115.87
2	НДШ	22,551,342.00	46,770,349.00	-24,219,007.00	207.39
3	Нүүрс худалдан авах	90,266,250.00	103,394,203.00	-13,127,953.00	114.54
4	Түлш шатахуун	39,110,040.00	62,707,972.00	-23,597,932.00	160.34
5	Цахилгааны зардал	32,915,629.00	36,259,477.00	-3,343,848.00	110.16
6	Хөдөлмөр хамгаалалын зардал	17,606,200.00	17,606,200.00	0.00	100.00
7	Шуудан холбоо	606,000.00	242,226.00	363,774.00	39.97
8	Бичиг хэрэг	511,500.00	897,500.00	-386,000.00	175.46
9	Томилолт	400,000.00	909,992.00	-509,992.00	227.50
10	Хангамжийн материал	11,473,000.00	11,141,500.00	331,500.00	97.11
11	Сэлбэг хэрэгсэл	14,703,000.00	21,931,000.00	-7,228,000.00	149.16
12	Урсгал засвар	39,900,000.00	3,990,000.00	35,910,000.00	10.00
13	Тэтгэмж урамшуулал	16,135,020.00	6,130,778.00	10,004,242.00	38.00
14	ТУЗ-ийн зардал	7,341,840.00	7,341,840.00	0.00	100.00
15	ТЗБАХЗ	69,497,400.00	69,497,400.00	0.00	100.00
16	Төлбөр хураамж	10,644,291.00	7,197,751.00	3,446,540.00	67.62
	Нийт зардлын дүн	533,988,491.00	581,791,376.00	-47,802,885.00	108.95

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**3.1 “Их-Уул дулаан” ХХК ба түүний үйл ажиллагаа**

Тус компани нь 100 хувь орон нутгийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Хөвсгөл аймаг, Их-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал хэрэгжүүлнэ. Компани нь 2011 оноос ОНӨААТҮГ хэлбэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 99 дүгээр тогтоолоор “Их-Уул дулаан” ХХК болон өөрчлөгдсөн. Компани нь нийт 26 ажиллагсадтай ба Төлөөлөн удирдах зөвлөлийн 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн үндсэн зорилго нь дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хооронд байгуулсан гэрээний дагуу ая тухтай ажиллах, сурч боловсрох, амьдрах боломжоор хангахад оршино. Энэ зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг эрхэлдэг.

- Дулаан үйлдвэрлэх, түгээх
- Цэвэр усаар хангаж, бохир ус татан зайлуулах

3.2 “Их-Уул дулаан” ХХК-ийн гадаад, дотоод орчин

Тус компанид дараах хууль эрх зүйн зохицуулалтуудыг үйл ажиллагаандаа голлон ашиглаж байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Компанийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Эрчим хүчний тухай хууль, хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль.

- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль,
- Бусад холбогдох хууль

Тайлант хугацаанд дээрх хуулиудад тус аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц хэмжээний өөрчлөлт гаргаагүй байна.

Тус байгууллага нь дотоод хяналт, шалгалтын комиссыг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/02 тушаалаар шинэчлэн томилсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Их-Уул дулаан” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу иж бүрэн бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Их-Уул дулаан” ХХК санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр захирлын тушаалаар баталсан бөгөөд 2023 оны 09 дүгээр сарын 1-ний дотор шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

Компани нь “Их-Уул дулаан” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэдэг ба бараа материалыг эхэлж зарлагдах аргаар бүртгэж тайлагнадаг

Нягтлан бодох бүртгэлд Санхүүгийн тооцоолох төв ХХК-ийн Leader программыг ашигладаг ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт нь бүрэн тохироогүй байна. **Тухайлбал:** Өртөг зардлыг зөв хуваарилж бүртгэх боломжгүй, гар ажиллагаа ихтэй зэрэг дутагдал байна.

“Их-Уул дулаан” ХХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9.8 сая төгрөгөөр буюу 1.8 хувиар буурч 554.6 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	44.5	1.6	(42.9)
Авлага	30.5	31.4	0.9
Бараа материал	13.2	55.1	41.9
Үндсэн хөрөнгө	442.5	411.6	(30.9)
Биет бус хөрөнгө	27.5	27.5	-
Нийт хөрөнгө	564.4	554.6	(9.8)
Өр төлбөр	0.5	2.4	1.9
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	563.9	552.2	(11.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	564.4	554.6	(9.8)

Тайлант онд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 42.9 сая төгрөгөөр буурч 1.6 сая төгрөг болсон байна. Үүнд шатахууны үнэ нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл тайлант онд өмнөх оноос 0.9 сая төгрөгөөр өсөж 31.4 сая төгрөг болсон ба түрээсийн гэрээгээр халуун ус ажиллуулж байсан иргэдээс авах 11.2 сая төгрөгийн авлагыг шүүхээр шийдвэрлүүлж байгаа.

Бараа материалын үлдэгдэл тайлант онд өмнөх оноос 41.9 сая төгрөгөөр өсөж 55.1 сая төгрөг болсон байна. Үүнд:

- Шатахууны үнэ ханш болон бараа материалын үнэ нэмэгдсэн
- Нүүрсний үнэ ханш нэмэгдсэн
- “Их-Уул дулаан” ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 08 дугаар тогтоолоор түлш шатахууны зардалд 15.0 сая төгрөг тодотгуулж халаалтын тогоо авсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 30.9 сая төгрөгөөр багассан нь элэгдлийн зардал өндөр байсантай холбоотой байна.

Өр төлбөр 1.9 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн нэгж, ард иргэдээс авах халаалтын төлбөр болон татварын өртэй холбоотой.

Болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн талаар:

Халуун ус түрээсээр ажиллуулж байсан хувь хүмүүсээс авах 11.2 сая төгрөгийн авлагыг шүүхээр шийдвэрлүүлж байгаа. Тайлангийн дараах үйл явдлыг хянахад шүүхийн шийдвэр гараагүй байна.

3.5 Зорилтот түвшин, төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 119 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралаар “Их-Уул дулаан” ХХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 15 дугаар тогтоолоор бизнес төлөвлөгөөг нийт орлогыг 535.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 534.0 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 1.1 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

“Их-Уул дулаан” ХХК-ын ТУЗ-ын 2022 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн 09 тоот тогтоолоор бизнес төлөвлөгөөний нийт зардлыг 581.8 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Гүйцэтгэлээр 476.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 581.8 сая төгрөгийн зардал гаргаж ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 476.5 сая төгрөг байгаа нь төлөвлөснөөс 58.6 сая төгрөг буюу 11 хувиар бага байна. Үүнд: 2022 оны төлөвлөгөөнд шинэ сургууль ашиглалтад орох тооцоолол хийгдсэн боловч тайлант онд ашиглалтад ороогүй учраас төлөвлөгөө тасарсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 581.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 47.8 сая төгрөг буюу 8.9 хувиар илүү зарцуулсан гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Шатахууны үнэ ханш, болон гэрэл, цахилгааны төлбөр өссөн
- Тайланд онд 1тн нүүрсний ханш 9,400 төгрөгөөр өссөн нь гол нөлөөг үзүүлсэн байна.

Хүснэгт 2. 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

дд	Үзүүлэлт	2022			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл				
1	Халаалтын орлого /НӨАТ-тай дүн/	522.0	444.3	77.7	85.1
	Цэвэр, бохир усны орлого	13.1	19.5	6.4	149.4
	Бусад орлого	-	12.6	12.0	
2	НИЙТ ОРЛОГО	535.1	476.5	(58.6)	89.0
3	НИЙТ ЗАРДАЛ	534.0	581.8	47.8	108.9
4	Татварын өмнөх ашиг	1.1	0.1	(1.0)	11.0
5	Цэвэр ашиг /алдагдал/	1.0	(36.1)	(37.1)	
8	Нийт ажиллагсдын тоо	26	26	-	100.0
9	Нийт цалингийн сан	160.3	185.8	25.5	115.8
15	НИЙТ АВЛАГА	36.7	34.4	(2.3)	93.7
16	НИЙТ ӨГЛӨГ	0.5	42.3	41.8	
	Үүнээс: Богино хугацаат	0.5	42.3	41.8	

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Их-Уул дулаан” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд компанийн дүрэм, үндсэн хөрөнгө, хууль тогтоомжийн хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, программ хангамжтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

“Их-Уул дулаан” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 9.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 6.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томиллолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд урсгал засварын зардлаас 39.9 сая төгрөгийн офиссын барилга бэлтгэсэн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Компанийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох бизнес төлөвлөгөөний тайлан, үйлдвэрлэлийн бусад үйл ажиллагаа, худалдан авах ажиллагааны тайлан зэрэг нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 4.4 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 3.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	3.8	1	3.8	100
Зөвлөмж	4	0.6	4	0.6	100
Нийт дүн	5	4.4	5	4.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- “Их-Уул дулаан” ХХК-ын ТУЗ нь 2022 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн 9 тоот тогтоолоор Хөвсгөл аймгийн ИТХ-аас баталсан зорилтот түвшинд заасан зардлын дүнг 47.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан "Орон нутгийн өмчит компаниудын 2022 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин батлах тухай" тогтоолын 4 дүгээр хавсралттай нийцэхгүй байна.
- Аймгийн ИТХ-д зорилтот түвшнийг нэмэгдүүлэх хүсэлт тавьсан боловч ТУЗ-аар шийдвэрлүүлэх чиглэл өгсөн. Цаашид зорилтот түвшний зардлын дээд хязгаарыг нэмэгдүүлэхдээ аймгийн ИТХ-ын тогтоолоор батлуулж байгаа эсэхийг дараагийн аудитын анхаарах асуудал гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 72.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 39.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 32.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Тайлант онд урсгал засварын зардлаас 39.9 сая төгрөгийн конторын барилга бэлтгэсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7.1 “Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгаанаар ашиглах боломжгүй болохыг тогтоосон тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр гарснаас бусад тохиолдолд захиргааны зориулалтаар барилга шинээр барихыг хориглоно” заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд анхан шатны баримтын бүрдэл дутуу 32.7 сая төгрөгийн ажил гүйлгээг хийж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дах заалт зөрчсөн, "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж ажиллах.

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: “Их-Уул дулаан” ХХК нь 2018 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг ашиглаж байгаа бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад журам, тушаалуудад гарсан өөрчлөлт, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтгүйгээр ажил гүйлгээг хийж бүртгэсэн	1	32.7					1	32.7				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шаардлага хангаагүй	1	0					1	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Урсгал засварын зардлаас конторын барилга бэлтгэсэн	1	39.9					1	39.9	

АУДИТЫН ТАЙЛАНГ
ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АХЛАХ АУДИТОР

Б.ДАВААНЫМ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

ЧАНАРЫН ХЯНАЛТ, АУДИТОР

Х.ДИЙМАА

Н.БАДАМХАНД

